



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/395

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын нутаг дэвсгэр (Гандан-1-111а)-д байршилтай иргэн Эрдэнэчимэг овогтой Мөнхжаргал (ЗЮ:82080701)-ын орон сууцны зориулалттай 34 м.кв (0,0034га) газрыг иргэн Сугир овогтой Мөнхсайхан (ХА:70092169)-д зориулалтаар нь шилжүүлж 24 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/168 дугаар захирамжийн иргэн Э.Мөнхжаргал-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000019851 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210525